



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/39 ЦУА-2018/20/СТА-ТЦ/Э Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай


Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материалын тооцоог алдаатай бодсон **1,048,884.00** /Нэг сая дөчин найман мянга найман зуун наян дөрвөн/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 4 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар батлагдсан /Цэцэрлэг сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм"-д тогтоосон нормативыг баримтлаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./ гэж заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөвөгүй гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалтыг хийх, хүнсний материалын тооцоог дахин хийж залруулах.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Б.Цэцэгжаргал, нягтлан бодогч О.Ууганбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫН  
ӨГСӨН:  
АУДИТОР  Б.ГАНТУЯА  
4817144213  
ЗЮА6639 0871 75

АЛБАН ШААРДЛАГЫН  
ЗӨВШӨӨРСӨН:  
ЭРХЛЭГЧ  Б.ЦЭЦЭГЖАРГАЛ  
НЯГТЛАН БОДОГЧ  О.УУГАНБААТАР  
25Д0002

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.